



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 3 (432)

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Үндэсний спортын III наадам зохион байгуулах тухай*
- *Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгээрийн хэмжээг нэмэгдүүлэх тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2006 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2006 оны нэгдүгээр сарын 21

№3 (432)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

34.	Засгийн газрыг огцруулах тухай	Дугаар 02	57
-----	--------------------------------	-----------	----

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

35.	Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Дугаар 224	58
36.	Журам батлах тухай	Дугаар 233	58
37.	Хөтөлбөр батлах тухай	Дугаар 234	64
38.	Үндэсний спортын III наадам зохион байгуулах тухай	Дугаар 235	70
39.	Журам батлах тухай	Дугаар 237	70
40.	Журам батлах тухай	Дугаар 238	72
41.	Ажлаас чөлөөлөх тухай	Дугаар 240	75
42.	Засгийн газрын агентлагийг татан буулгах тухай	Дугаар 241	75
43.	Ажлаас чөлөөлөх тухай	Дугаар 242	75
44.	Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай	Дугаар 247	75
45.	Нэрэмжит болгох тухай	Дугаар 250	76
46.	Хэлэлцээр батлах тухай	Дугаар 251	76
47.	Олон улсын нисэх буудлын нэрийг өөрчлөх тухай	Дугаар 255	76

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Засгийн газрыг огцруулах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Дөчин гуравдугаар зүйлийн 2 дахь хэсэг, ил санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Цахиагийн Элбэгдоржийн тэргүүлсэн Засгийн газрыг бүрэн бүрэлдэхүүнээр нь огцруулсугай.

2. Шинэ ерөнхий сайдыг томилогдох хүртэл үүрэгт ажлаа гүйцэтгэж байхыг Ерөнхий

сайд /Ц.Элбэгдорж/-д, шинээр Засгийн газрын гишүүн сайд томилогдтол үүрэгт ажлаа гүйцэтгэж байхыг Засгийн газрын гишүүдэд даалгасугай.

3. Энэ тогтоолыг 2006 оны 1 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 10 дугаар сарын 27—ны өдөр

Дугаар 224

Улаанбаатар хот

Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 95.10-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Дүрэм батлах тухай" Засгийн газрын 2000 оны 107 дугаар тогтоолоор баталсан "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм"-д дор дурдсан агуулгатай 8¹, 18¹ гэсэн зүйл нэмсүгэй:

1.1. "8¹. Ажил, албан тушаал хавсран ажиллаж байгаа хүн осолд орвол осол гарсан тухайн байгууллага судалж бүртгэнэ."

1.2. "18¹. Хүний амь үрэгдсэн, осолтой холбогдох шинжээчийн дүгнэлтийг хөдөлмөрийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас томилсон комисс гаргана.

18¹.1. Дараахь үйлдвэрлэлийн ослыг хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч судалж бүртгэнэ:

а/байгалийн гэнэтийн аюул, гамшиг, хөнөөх хэрэгслийн голомт, сүйрэл, дэлбэрэлтийн үед гарсан осол;

6/5 хүртэлх ажилтантай байгууллагад гарсан осол;

в/иргэд, хуулийн этгээдтэй гэрээ хэлцлээр ажил гүйцэтгэх үед гарсан осол;

г/ажил үүргээ гүйцэтгэж байх үед гарсан зам тээврийн осол.

Уг ослыг замын цагдаагийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн тухайн орон нутгийн хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч судалж баталгаажуулна."

2. Дүрмийн 7-гийн "в" заалтын "... хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны горимыг ноцтой зөрчсөнөөс осолдох;" гэснийг "технологийн горимыг ажилтан өөрөө санаатайгаар өөрчилснөөс осолдох;" гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ШАДАР САЙД

Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН
САЙД

Д.ДОРЛИГЖАВ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 10 дугаар сарын 23—ны өдөр

Дугаар 233

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2-т заасныг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1 "Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам"-ыг 1 дүгээр хавсралт, "Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа, жилд байгуулах элэгдлийн хэмжээ"-г 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталж, 2006 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдүүлэхээр тогтоосугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Үндсэн хөрөнгийн элэгдлийн хувь, үнэлгээний тухай" Засгийн газрын 1994 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 8 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Ц.ЭЛБЭГДОРЖ

САНГИЙН САЙД

Н.АЛТАНХУЯГ

Засгийн газрын 2005 оны 233 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЭЛЭГДЭЛ ТООЦОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 40.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10.1-ийг хэрэгжүүлэх, аж ахуйн нэгж, байгууллагын үндсэн хөрөнгийн ашиглахаар тооцсон хугацаа, элэгдлийг тооцоход энэхүү журмыг баримтална.

1.2. Төсөвт байгууллага нь үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцохдоо "Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 17"-г дагаж мөрдөнө.

Хоёр. Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох

2.1. Аж ахуйн нэгж, байгууллага нь энэ журмын 2.2-т зааснаас бусад бүх үндсэн хөрөнгийн

элэгдлийг тооцож, тайлангийн хугацааны үйл ажиллагааны болон холбогдох зардалд шингээнэ.

2.2. Дор дурдсан үндсэн хөрөнгөд элэгдэл тооцохгүй:

- а/ газар;
- б/ худалдахад зориулсан үндсэн хөрөнгө, дуусаагүй барилга;
- в/ түр ашиглаагүй буюу нөөцөд байгаа үндсэн хөрөнгө;
- г/ номын сангийн нөөц, музей үзмэр, урлагийн цуглуулга.

2.3. Төсөвт байгууллага нь энэ тогтоолын 2 дугаар хавсралтад заасан үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацааг дагаж мөрдөн, шулуун шугамын аргаар элэгдлийг тооцоо.

2.4. Шулуун шугамын аргаар жилд байгуулах элэгдлийн хэмжээг тодорхойлохдоо дансны үнээс үлдэх өргийг хассан дүнг ашиглах жилийн тоонд хуваана.

2.5. Энэхүү журмын 1.2-т зааснаас бусад этгээд нь үндсэн хөрөнгийн ашиглахаар тооцсон хугацаа, элэгдэл тооцохдоо "Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт 16"-г дагаж

мөрдөн байгууллагынхаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгасан байна.

2.6. Энэ журмын 1.2-т зааснаас бусад этгээд нь хөрөнгийн ашиглахаар тооцсон хугацааг тогтоохдоо машин, тоног төхөөрөмжийн техникийн паспорт, адил төстэй хөрөнгийн үзүүлэлтийг үндэслэн техникийн болон санхүүгийн ажилтнууд оролцсон комиссоос гаргасан дүгнэлт, тооцоог үндэслэнэ.

2.7. Хөрөнгийн ашиглахаар тооцсон хугацаанд өөрчлөлт орвол элэгдлийн хувь хэмжээг дахин тооцоолно.

2.8. Энэ журмын 1.2-т зааснаас бусад этгээд нь хөрөнгийнхөө ашиглагдах хугацааг тодорхойлох боломжгүй тохиолдолд энэ тогтоолын 2 дугаар хавсралтад заасан үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацааг ашиглаж болно.

2.9. Хөрөнгийн зах зээлийн үнэ нь дансны үнээс их хэмжээгээр зөрсөн тохиолдолд дахин үнэлгээ хийнэ.

2.10. Тодорхой бүлэгт ороогүй эсхүл шинэ нэр төрлийн үндсэн хөрөнгийн ашиглагдах хугацаа, элэгдлийн хувийг тогтоохдоо адил төстэй үндсэн хөрөнгийг жишиг болгох байдлаар тодорхойлно.

Засгийн газрын 2005 оны 233 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЭЛЭГДЭЛ ТООЦОХОД БАРИМТЛАХ ХУГАЦАА, ЖИЛД БАЙГУУЛАХ ЭЛЭГДЛИЙН ХЭМЖЭЭ

№	Үндсэн хөрөнгийн төрөл, зүйл	Элэгдэл тооцоход баримтлах хугацаа /жил/	Жилд байгуулах элэгдлийн хэмжээ /хувь/
Нэг. Барилга байгууламж			
1	Төмөр бетон, угсармал байшин, төмөр сараалжтай ердийн, тоосгон болон блокон барилга	60	1,6
2	Холимог бүтэцтэй болон дүнзэн байшин	36	2,7
3	Зуслангийн модон байшин, угсармал болон бусад хөнгөвчилсөн хийцийн модон байшин	15	6,6
4	Зоорь, хүлэмж	10-20	10-5
5	Малын хашаа	15	6,6
6	Худаг	20	5
7	Услалтын систем	25	4
8	Гэр	5	20
9	Контейнер /төмөр чингэлэг/	20	5
Хоёр. Машин, тоног төхөөрөмж			
1. Барилгын материалын үйлдвэрийн машин, тоног төхөөрөмж			
10	Дугуй болон хонгил зуух, тээрэм, хайлах, цутгах, төмөр эдлэл хийх тоног төхөөрөмж, хатаагуур, түүний тоноглол	10	10
11	Эргэх зуух, металл боловсруулах суурь машин, хайлах, цутгах, тоосгоны шавар боловсруулах болон механизмын засварын үйлдвэрийн технологийн тоног төхөөрөмж, гидро карьер, цахилгаан зуух, керамик эдлэхүүний бүх төрлийн тунгаагч, арматур сунгах, таслах, нугалах болон эрдэс хөвөн эдлэхүүний тоног төхөөрөмж	10	10
12	Бетон эдлэл хэвлэх болон зуурмагийн үзэлийн бүх төхөөрөмж, бетон зуурагч, карьерын тэжээгүүр, бутлах, ялгах, шигших тоног төхөөрөмж, тоосго, хавтанцар үйлдвэрлэх шахуурга	8	12,5
13	Доргиурт ширээ	4	25

14	Угааж цэвэрлэх, тослох, цэнэглэх, задалж угсрах зэрэг зориулалтын тоног төхөөрөмж 2.Эрчим хүч, уул уурхайн үйлдвэрийн тоног төхөөрөмж	5	20
15	35 кв-аас дээш хүчдэлтэй цахилгаан дамжуулах агаарын болон кабель шугам, дулааны шугам, далд уурхайн төмөр, төмөр бетон бэхлэгээ, уурхайн бусад байгууламж	35	2.8
16	Бүх төрлийн зуух, турбин, 35 кв хүртэл хүчдэлтэй цахилгаан дамжуулах агаарын болон кабель шугам дэд өртөө, 5-аас дээш шоо метр багтаамжийн шанагатай экскаватор, илчит тэрэг, цахилгаан зүтгүүр	15	6,6
17	Минутад 500 хүртэл болон 501-1000 эргэх хурдтай дизель генератор, өрмийн машин, бульдозер, автогрейдер, 32-оос дээш шоо метр багтаамжтай думпкар, төрөл бүрийн бутлагч, шигшүүр, конвейер, төрөл бүрийн насос, нар, салхины цахилгаан үүсгүүр	8	12,5
18	Авто самосвал, дизель генератор, 32 шоо метр хүртэл багтаамжтай думпкар, эрдэс түүхий эд боловсруулах төхөөрөмжүүд, туузан дамжуулагч 3. Ноос боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмж	7	14,2
19	Хялгас ялгах, самнах, ноос сэмлэх, сэгсрэх, зулхай шивэх, эсгий гутал хийх тоног төхөөрөмж	10	10
20	Зүү, кардаар самнах, зэрэх, эрчлэх, давхарлан ороох, ноос, утас хатаах, эсгий, эсгий гутал агшаах, нягтруулах, эсгий гутал уллах, хэвлэх, ноос нэхэх, дугуй сүлжих, нэхмэл эдлэл хийх тоног төхөөрөмж, нэхмэлийн болон туузлах, хивс нэхэх машин, бохир ноос угаах, хатаах агрегат, босоо шахуургат пресс, ноос зөөвөрлөх хийн төхөөрөмж, чийгшүүлэх тоноглол, ноос боловсруулах үйлдвэрийн бусад туслах машин	7	14,2
21	Сүлжих машин төхөөрөмж	8	12,5
22	Ноос баглах зориулалт бүхий хэвтээ шахуургат пресс, даахь урах машин 4. Арьс, шир боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмж	5	20
23	Арьсанд механик боловсруулалт хийх, арьс хатаах төхөөрөмж, арьс будах агрегат	8	12,5
24	Арьс махлах, хуваах, шахах, хусах, индүүдэх төхөөрөмж, арьс шир боловсруулахад хэрэглэгдэх барабан, баркас	8	12,5
25	Нойтон боловсруулалтын туслах төхөөрөмж 5. Оёдлын үйлдвэрийн тоног төхөөрөмж	5	20
26	Бүх төрлийн оёдлын машин, эсгүүр, нэхий, арьс ширний машин, гутлын ул, эсгий үйлдвэрлэх төхөөрөмж, гутал уллах, хэвлэх машин, гутлын хэвлүүр, цавуу, химийн уусмал найруулах төхөөрөмж	8	12,5
27	Оёдлын үйлдвэрийн гүйцэтгэн боловсруулах ажлын машин, тоног төхөөрөмж	7	14,2
28	Дамжлага дундын бусад тоног төхөөрөмж 6. Мод боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмж	5	20
29	Хатаалгын камер, тунель, кабин, өнгөлгөөний суурь машин, фанерь хуулганы, шүдэнзний, цаас, картоны үйлдвэрийн машин, мод гуалин буулгах, ялгах төхөөрөмж, модон хийц боловсруулах суурь машин, зоргодос гаргах машин, хавтангийн үйлдвэрийн тоног төхөөрөмж	8	12,5
30	Халуун, хүйтэн шахуурган хавчаар, хавтан хийц боловсруулах суурь машин, хавтангийн үйлдвэрийн барабан, хатаагуур, дагалдах төхөөрөмж	7	14,2
31	Хөрөө рам, дагахдах тоноглол	5	20
32	Мод цагаалж ачих трактор, мод тээврийн автомашин, чиргүүл	3	33,3
33	Дотоод шаталтат хөдөлгүүрт хөрөө	3	33,3

7. Шил, шаазангийн үйлдвэрийн тоног төхөөрөмж		
34	Түүхий эд шатаах, хатаах зуух, шаазан шатаах зуух	10 10
35	Түүхий эд бутлах, тээрэмдэх, шигших төхөөрөмж, шаазан эдлэлийн масс бэлтгэх машин, шилэн эдлэлд гүйцэтгэн боловсруулалт хийх төхөөрөмж	8 12,5
36	Шил шарах, уяраах зуух, шилэн эдлэл шахаж хэвлэх автомат	7 14,2
37	Аяга хэвлэх машин, аяга шатаах шугам, шил хайлуулах зуух, шаазан бүтээгдэхүүн пааландаж угаах шугам	6 16,6
8. Хүнсний үйлдвэрийн тоног төхөөрөмж		
38	Хөргөлт, мал нядлаганы болон саван, жимс, ногооны консерв, талх, нарийн боов, гурил, жигнэмэг, архи, дарс үйлдвэрлэх, өлөн гэдэс боловсруулах тоног төхөөрөмж	8 12,5
39	Хиам, консерв, гоймон, пүнтүүз, чихэр, сүү, ливо, амтат ус, квас, спирт үйлдвэрлэх, хаягдал, яс боловсруулах машин, тоног төхөөрөмж	8 12,5
40	Давс боловсруулах, загас олборлох төхөөрөмж	5 20
9. Хэвлэлийн үйлдвэрийн машин, тоног төхөөрөмж		
41	Өндөр хэвлэлийн ротац, том болон дунд форматын хэвлэлийн хавтгай машин, үсэг цутгах, мөрөөр цутгах, цаас нугалах, үдэх болон цуглуулгын машин, цаас хөвж огтлох, хавтас хийх машин	8 12,5
42	Офсет хэвлэлийн бүх төрлийн машин, тоног төхөөрөмж, мөрөөр өрж цутгах машин, өндөр хэвлэлийн бага форматын хавтгай тигель машин, товхимлын агрегатмашин, цавуун бэхэлгээ хийх, бүх төрлийн огтолгооны машин, блок боловсруулах болон дэвтэрлэгээний иж бүрэн агрегат	8 12,5
10. Хөдөө аж ахуй машин, тоног төхөөрөмж		
43	Зөгийн аж ахуйн тоног төхөөрөмж	12 8,3
44	Бороожуулагч машин, агрегат, дугуйт болон гинжит трактор, үр тарианы комбайн, тариа цэвэрлэх, хатаах, няцлах, бутлах, шигших, дугаарлах, ачих, буулгах төхөөрөмж, гурил, тэжээлийн үйлдвэрийн бусад тоног төхөөрөмж, усны бүх төрлийн зөөврийн шахуурга, шувуу нядлах, шувууны мах боловсруулах төхөөрөмж	10 10
45	Өөрөө явагч механизм, төрөл бүрийн хөрс сийрүүлэгч, анжис, хөдөө аж ахуйн чиргүүл, дүүжин машин, мал, гахай, ан амьтдын аж ахуйн зориулалттай тоног төхөөрөмж, инкубатор, шувууны суудлын задгай төхөөрөмж, торон хайс, үр тариа холих, жорлох болон цехийн дотоод тээврийн тоног төхөөрөмж	7 14,2
46	Үр тариа хальслах, өнгөлөх тоног төхөөрөмж	5 20
47	Шувууны байрны салхивчийн төхөөрөмж	4 25
11. Зам, гүүрийн болон барилгын машин, тоног төхөөрөмж		
48	Асфальт холигч, 15 шоо метрээс илүү багтаамжтай шанага бүхий скрепер, зам гүүрийн төхөөрөмжөөр тоноглогдсон бусад машин	6-10 16,6-10
49	Азродром, бетон хучилттай замд зориулсан иж бүрэн машин, 90-ээс дээш морины хүчтэй грейдер, скрепер, хайрга, дайрга тараах, хөрс холих, жижиглэх машин, асфальт дэвсгэг, 5-15 шоо метр багтаамжтай скрепер, өөрөө явагч индүү	6-8 16,6-12,5
50	Бульдозер	6-8 16,6-12,5
51	0,5-20, түүнээс дээш шоо метрийн шанагатай экскаватор	7-8 14,2-12,5
52	Автокран	8-10 12,5-10
53	Цамхагт өргөгч болон хийн дугуйт кран	8-10 12,5-10
54	Чулуу бутлах төхөөрөмж	6-10 16,6-10
55	Замын лабораторийн тоног төхөөрөмж	10 10
56	Суурин болон өөрөө явагч бетон зуурагч	6-10 16,6-10

57	Битумын агуулах	15	6,6
58	Битум зөөгч болон тараагч машин	10	10
12.Геологийн машин, тоног төхөөрөмж			
59	Бүх төрлийн оптик хэрэгсэл, лабораторийн цахилгаан техник, дээж бутлах, боловсруулах техник, жин хэмжүүр	5	20
60	Улирлын ажиллагаатай явуулын өрмийн суурь машин, өрөмдлөгийн тоног төхөөрөмж	5	20
61	Цохилтот болон хийн өрөмдлөгийн суурь машин, соронзон хайгуул, хүндийн хүч, чичирхийлэл, цооногийн судалгааны багаж, цахилгаан хайгуулын болон цацраг хэмжүүрийн багаж	5	20
62	Суурин өрмийн суурь машин	4	25
63	Шатаалгын бүх төрлийн цахилгаан зуух	3	33,3
13.Авто болон агаарын тээврийн хэрэгсэл			
64	Ачааны, суудлын автомашин, эмнэлгийн болон тусгай тоноглолтой тээврийн хэрэгсэл	6	16,6
65	Автобус, троллейбус, чиргүүл	6	16,6
66	Агаарын тээврийн хэрэгсэл /онгоц, нисдэг тэрэг/	22	4,5
67	Ачааны болон суудлын усан онгоц /металл/	13	7,6
68	Чиргүүл, төрөл бүрийн завь	7	14,2
69	Уулын мод зөөдөг машин механизм	3	33,3
14.Төмөр замын тээврийн хэрэгсэл			
70	Төмөр замын ул шороо, төмөр замын дээд хэсэг, төмөр бетон замын доогуурхи гарц, төмөр замын хиймэл төхөөрөмж	100	1,0
71	Бүх төрлийн вагон, илчит тэрэг, цистерн, зорчигчийн тавцан, вагон угаах тавцан, гүүрэн кран, зам тавигч төхөөрөмжтэй балласжуулагч, моторт тавцан, зам цэвэрлэгч, шалгагч хэлбэлзэл шингээгчийг турших машин, сонгох холбооны зогсоогуур	25	4,0
72	Вагон кузов засварлах машин, дрезина, хос дугуйн голын хүзүү зүлгэх, дугуй зорох, вагон засварлах машин, цахилгаан домкрат, дугуйн өнхрөх гадаргууг зорох, зүтгүүрийн дугуй зорох машин, замын хориг хашаа, сонгох холбооны дундаж цэг шилжүүлэх байгууламж, зам хэмжигч	14	7,1
73	25 тоннын хос дугуйт домкрат, 15 тоннын шингэний домкрат, төмөр замаар явдаг кран, үе угсрах машин	11	9,0
74	Замаас авагддаг дрезина, өртөөний ажиллагааг хянах телевизийн систем, зөөврийн радио холбоо, автомат хадгаламж	7	14,2
75	Шуруп эрэгдэгч, замын боолт болон шуруп чангалагч, үе угсрах тавцан, дэр модны цахилгаан чигжүүр, зам төмөр тайрагч, түлхэгч, зүлгэгч механизм, цасны хаалт, радио холбооны төхөөрөмж	5	20
76	Вагоны кузов угаах машин	3	33,3
77	Вагон пүүлэх хэмжих хэрэгсэл	10	10
78	Тээвэрт хэрэглэгдэж байгаа чингэлэг	10	10
15.Холбооны тоног төхөөрөмж			
79	Холбооны бүх төрлийн цамхаг, агаарын баганат болон кабель шугам, түүний суваг, тэдгээрийн бусад байгууламж	28	3,5
80	Радио, телевиз, телефон, телеграфын нягтруулга, холболт, дамжуулалтын төхөөрөмж, лабораторийн хэмжих хэрэгсэл, шуудангийн цахилгаан тоног төхөөрөмж	7	14,2
81	Холбооны хэрэглэгчийн энгийн техник хэрэгсэл, зай тэжээлийн байгууламж, суурин аккумулятор, гар станц, бүх төрлийн гагнуурын аппарат	5	20
82	Холбооны шилэн кабель	25	4
16.Худалдаа, нийтийн хоолны тоног төхөөрөмж			

83	Бага хүч чадлын болон суурин хөргөлтийн төхөөрөмж	13	7,6
84	Кассын автомат, хагас автомат аппарат, ачаа өргөх, буулгах, зөөх төхөөрөмж, дулаан, механик, жин хэмжүүрийн болон бусад төхөөрөмж	5	20
85	Ахуйн хэрэглээний хөргөгч, хөлдөөгч	4	25
	17. Шатахууны тоног төхөөрөмж		
86	Агуулах сав /ган резервуар/	20	5
87	Түгээгүүр, насос, ачих, буулгах төхөөрөмж	5	20
	18. Нийтийн аж ахуй, үйлчилгээний тоног төхөөрөмж		
88	Халаалтын болон хэрэглээний усны шугам, агаарын шугам, шугамын /өргөлтийн/ насос	21	4,7
89	Оёдол, угаалга, хими цэвэрлэгээний машин, халаах зуух, зүлэг, хяргах микротрактор	8	12,5
90	Гүний болон бохирын бүх төрлийн насос, бохирын станцын агааржуулагч	6	16,6
	19. Тооцоолон бодох техник, дохиолол хамгааллын хэрэгсэл, кино студийн тоног төхөөрөмж		
91	Тооцоолон бодох техник хэрэгсэл - Тасралтгүй ажиллагаатай тооцоолох техник	5	20
92	Дохиолол хамгааллын техник хэрэгсэл	10	10
93	Кино студи, кино театрын тоног төхөөрөмж, тасалгааны агааржуулагч	10	10
94	Мэдээлэл технологийн тоног төхөөрөмж, программ хангамж	4	25
95	Тавилга эд хогшил	10	10
96	Хөгжмийн хэрэгсэл, дуу авиа, радио, телевиз	5	20
97	Бие бялдаржуулах болон биеийн тамирын техник хэрэгсэл	5	20
98	Эмнэлгийн оношлогоо, эмчилгээний багаж, тоног төхөөрөмжүүд	8	12,5
99	Ариутгал, халдваргүйтэлийн тоног төхөөрөмж	10	10
100	Лабораторийн болон мэс засал, сэхээн амьдруулах, яаралтай тусламж, эрчимт эмчилгээний багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж	5	20
101	Хэмжих хэрэгслийн тоног төхөөрөмжүүд	5	20
102	Геологи хайгуул, ашиглалтын талбайд ашигладаг хэмжих, тохируулах багаж хэрэгсэл	5	20
103	Геологийн кадастрын зураг хэвлэх тоног төхөөрөмж	5	20
104	Газрын тосны хайгуул, олборлолтын талбайд хөдөө ашигладаг нүүдлийн сууц	5	20
Гурав. Нийтийн эзэмшлийн талбайн			
105	Сандал, сүүдрэвч, хогийн сав	10	10
106	Автобус, троллейбусны буудал	10	10
107	Хашаа, хашлага	8	12,5
108	Хад чулуун хашаа болон гинжин, төмөр, модон хашлага	8-25	12,5-4
109	Тоглоомын болон биеийн тамирын талбай	10	10
110	Угсармал төмөр бетон далан	60	1,6
111	Цутгамал бетон далан	10	10
112	Гадна реклам чимэглэл, тэмдэг	5	20
113	Гадна гэрэлтүүлгийн төхөөрөмж	10	10
Дөрөв. Улс, орон нутгийн чанартай зам, замын байгууламж			
114	Асфальт бетон хучилттай зам	13	7,6
115	Цемент бетон хучилттай зам	25	4
116	Хөнгөвчилсөн хучилттай зам	8	12,5
117	Хайрган зам	4	25
118	Сайжруулсан хөрсөн зам	2	50
119	Төмөр бетон гүүр	75	1,3
120	Модон гүүр	20	5

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр

Дугаар 234

Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай

НҮБ-ын Хүүхдийн эрхийн Конвенцийн Хүүхдийг худалдах, биеэ үнэлэх, садар самуунд татагдахаас хамгаалах тухай Нэмэлт Протокол, Хүн амын хөгжлийн талээр төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хүн худалдах ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах Үндэсний хөтөлбөрийг 1 дүгээр, хөтөлбөрийг 2006-2008 онд хэрэгжүүлэх ажлын чиглэлийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих зөвлөл байгуулан ажиллуулж хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Нийгмийн хамгаалал,

хөдөлмөрийн сайд Ц.Баярсайхан, Монгол Улсын сайд Д.Дорлигжав нарт үүрэг болгосугай.

3. Хөтөлбөрийг салбар, орон нутгийнхаа түвшинд хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулахыг холбогдох сайд, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлэхийг Сангийн сайд Н.Алтанхуягт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Ц.ЭЛБЭГДОРЖ

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД БӨГӨӨД
НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН
САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Т.ГАНДИ

Засгийн газрын 2005 оны 234 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

ХҮН ХУДАЛДАХ ЯЛАНГУЯА ХҮҮХЭД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ БЭЛГИЙН МӨЛЖЛӨГИЙН ЗОРИЛГООР АШИГЛАХААС ХАМГААЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Үндэслэл

Дэлхий дахинд, ялангуяа Зүүн Ази, Номхон далайн бүс нутгийн хэмжээнд хүн худалдах, хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглах, биеийг нь үнэлүүлэн орлого олохоор нэг улсын дотор болон хил дамжуулан худалдах асуудал сүүлийн үед их хэмжээгээр өргөжиж, эвсэж, хар тамхины наймааны дараа орох болсон байна.

Судалгаанаас үзэхэд хүнийг үйлдвэр, тариалангийн талбайд ажиллуулах, гэрийн ажилд зарцлах, тахир дутуу болгон гуйланчлуулах, эрхтэнг нь авч худалдах, бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглах, биеийг нь үнэлүүлэх, садар самууны сурталчилгаа болон үзүүлбэр, интернэтийн буюу cyber sex-ийн сурталчилгаанд ашиглах зорилгоор худалддаг байна. Хүн худалдах гэмт хэргийн 75 орчим хувийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглах, худалдах хэлбэр эзэлдэг ажээ.

Зарим эх сурвалжаас үзэхэд дэлхийн хэмжээнд нэг жилийн дотор 0.7-2 сая хүн, Европын Холбооноос тогтоосноор зөвхөн баруун европын орнуудад жилд 120000 хүн худалдагдаж байгаагийн нэлээд хэсгийг есвөр насны охид, хөвгүүд эзэлдэг байна.

Хөгжиж байгаа орны хүүхэд, эмэгтэйчүүдийг улсын дотор, хөрш зэргэлдээ улс

руу болон Ази, Европын хөгжингүй орнууд руу өндөр цалинтай ажилд зуучлах, гэрлүүлэх зэрэг хуурамч зарыг ашиглан мэхлэх аваачдаг бөгөөд улмаар хууль бус орогнол, бичиг баримтын зөрчил, мөнгөгүй, хэл мэдэхгүйн улмаас тусламж авах бололцоогүй байдлыг нь ашиглан эрхшээлдээ оруулж биеийг нь үнэлүүлэн орлого олдог байна.

Сүүлийн жилүүдэд монгол охид, эмэгтэйчүүд төрөл бүрийн зар, зуучлалд хууртагдан Макао, Хонконг, Хятад, Европын зарим оронд очих болсон бөгөөд дээр дурдсан эмзэг байдлаас шалтгаалан хүчирхийлэл, дарангуйлалд автах, бие махбодь сэтгэл зүйн хохирол үзэх зэргээр эрх нь зөрчигдөх болсон байна. Дээрх гэмт хэргийн улмаас хохирогчдын дотор бие бялдар, окун ухааны хувьд ч төгс төлөвшөөгүй байдгийн хувьд хүүхдийг онцгойлон анхаарч тэдний эрхийг хамгаалах, ялангуяа эрсдлээс хамгаалах эрх зүйн зохих хамгаалал бий болгох зайлшгүй шаардлага тавигдаж байна.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн 34, 35 дугаар зүйлд Конвенцид нэгдэн орсон орны Засгийн газар хүүхдийг мөлжлөгийн зорилгоор бэлэгсийн харьцаа, садар самууныг дүрсэлсэн арга хэмжээнд ашиглах, хүүхдийг аливаа зорилго, хэлбэрээр хулгайлах, худалдах, хууль бусаар хил нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлэх шаардлагатай бүх арга хэмжээг авна гэж заасан.

Мөн 2001 онд батлагдсан Хүүхдийг худалдах, биеэ үнэлж, садар самуунд татагдахаас хамгаалах тухай Хүүхдийн эрхийн тухай Конвенцид оруулсан Нэмэлт Протокол, Олон улсын хүүхдийн байгууллагын Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг хориглох, нэн даруй устгах тухай 182 дугаар Конвенцид Монгол Улс тус тус нэгдэн орсноор хүүхдийн хамгааллыг сайжруулах үүргийг хүлээсэн юм.

Монгол Улс эдгээр Конвенц, Протоколд нэгдэж, дэлхийн болон бүс нутгийн хэмжээний хурал, зөвлөлгөөний тунхаглал, үйл ажиллагааны хөтөлбөрийг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх үүргийг хүлээж ирсэн боловч хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглах, хил дамжуулан худалдахаас хамгаалах Үндэсний хөтөлбөр боловсруулж байгаагүй нь өнгөрсөн хугацаанд энэ асуудал төдийлөн хурцаар тавигдаж байгаагүйтэй холбоотой юм. Харин 2004 онд Улсын Их Хурлаас батлагдсан Хүн амын хөгжлийн талаар төрөөс баримтлах бодлого, 2002 онд батлагдсан Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах Үндэсний хөтөлбөрт хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгт ашиглах, хил дамжуулан худалдахаас хамгаалах асуудал тусгагдсан юм.

Иймд нийгмийн хүрээнд гарч байгаа өөрчлөлт, даяарчлал, ядуурал, иргэдийн ёс суртахууны өөрчлөлттэй холбоотойгоор хүүхэд, эмэгтэйчүүдийн эрхийг хэрэгжүүлэх асуудлыг онцгойлон үзэж "Хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах Үндэсний хөтөлбөр"-ийг боловсруулан хэрэгжүүлэх шаардлага гарч байна.

Хүний эрхийн асуудал нь нийгэм, эдийн засгийн бүхий л салбар, иргэний нийгмийн хамтын ажиллагааг шаардсан асуудал бөгөөд Засгийн газар, олон улсын байгууллага, иргэний нийгэм, хувийн хэвшил, үүний дотор аялал жуулчлал, үйлчилгээ, хууль хяналтын байгууллагын хамтын ажиллагааг уялдуулснаар үр дүнтэй хэрэгжих билээ.

Хоёр. Хөтөлбөрийн эрхэм зорилго

2.1. Хүн худалдах ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалахад энэхүү хөтөлбөрийн эрхэм зорилго оршино.

Гурав. Хөтөлбөрийн зорилт

3.1. Хүн худалдах ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахын эсрэг Монгол Улсын олон улсын гэрээний дагуу хүлээсэн үүрэг, бусад баримт бичигт туссан үйл ажиллагааг үндэсний түвшинд хэрэгжүүлэх.

3.2. Хүн худалдах ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, тэмцэхтэй холбогдсон эрх зүйн орчинг боловсруулж болгох.

3.3. Хүн худалдах ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах, тэднийг садар самуунд уруу татах, дотооддоо болон хил дамжуулан худалдах гэмт хэрэг, түүний улмаас хүүхэд, эмэгтэйчүүдэд учирч болох хохирол, гарах үр дагаврын талаархи иргэний нийгэм, эцэг эх, хүүхэд, залуучуудын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх.

3.4. Нийгмийн ажилтан болон боловсрол, аялал жуулчлал, үйлчилгээ, хууль хяналтын байгууллагын ажилтны чадавхийг бэхжүүлж, хүүхэд, эмэгтэйчүүдтэй ажиллах мэргэжлийн үр чадварыг нэмэгдүүлэх.

3.5. Хүн худалдах ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглах, дотооддоо болон хил дамжуулан худалдагдахаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, хохирогчийг нөхөн сэргээх, нийгэмшүүлэхэд төрийн, иргэний нийгмийн болон олон улсын байгууллагын оролцоог нэмэгдүүлж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах.

3.6. Хүн худалдах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх, нийгэмшүүлэхэд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж тэдний зүгээс гарсан санал санаачилгыг дэмжих.

Дөрөв. Хөтөлбөрийн санхүүжилт, хугацаа

4.1. Хөтөлбөрийн санхүүжилт дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

4.1.1. улс, орон нутгийн төсөөс хуваарилах хөрөнгө;

4.1.2. хандивлагч орон болон олон улсын байгууллагаас хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, тусламж, хандивын хөрөнгө;

4.1.3. төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн санаачилгаар хуримтлагдсан тусламж, хандивын хөрөнгө;

4.1.4. хүүхдийн хөгжил, хамгаалалд зориулсан гадаад, дотоодын хөрөнгө оруулалт;

4.1.5. бусад эх үүсвэр.

4.2. Хүн худалдах, хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглах, худалдахаас хамгаалах Үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагааг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан хөрөнгийн 5 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгөөр санхүүжүүлнэ.

4.3. Хүн худалдах, хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглах, худалдах,

хил дамжуулан худалдахаас урьдчилан сэргийлэх эдгээр гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, хохирсон хүүхэд, эмэгтэйчүүдийг нөхөн сэргээх ажилд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг тухайн жилийн улсын болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэх асуудлыг Сангийн яам, бүх шатны Засаг дарга хариуцна.

4.4. Хөтөлбөрийг 2015 он хүртэл дараахь үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

Нэгдүгээр үе шат:	2006-2008
Хоёрдугаар үе шат:	2008-2011
Гуравдугаар үе шат:	2011-2014

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараахь зарчмыг баримтална:

5.1.1. хүний эрхийг дээдэлсэн, эрсдлээс хамгаалах ээлтэй орчин бүрдүүлэх;

Хүний эрхийн түгээмэл тунхаглал, хүүхэд болон эмэгтэйчүүдийн эрхийн асуудлаархи олон улсын баримт бичиг, Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан хүний эрхийг дээдэлж, хүүхэд бүрийг өөрийн гэр бүлд, эцэг эхийн хайр халамжинд эрүүл энх өсч хөгжих, сурч боловсрох, сэтгэл хангалуун амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

5.1.2. иргэдэд ялгаварлалгүй хандаж нэр төрийг нь эрхэмлэн хамгаалах;

Бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглагдсан, худалдагдсан, эрсдэлд өртсөн, хохирсон эмэгтэйчүүд, хүүхэд бүрт амьдралын байдал, яс үндэс, хэл соёл, хүмүүжлийн байдлаас үл хамааран ялгаварлалгүй хандаж нэр төрийг нь хамгаалах асуудлыг онцгойлон анхаарна.

5.1.3. хүн худалдахаас хамгаалах үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоог хангах;

Хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглах, худалдахаас хамгаалах үйл ажиллагаанд төрийн бус байгууллага, өсвөр үе, залуучууд, олон нийтийн оролцоог дэмжинэ.

5.1.4. хүүхэд, эмэгтэйчүүдийг эрсдлээс хамгаалах, нөхөн сэргээж нийгэмшүүлэхэд үзүүлэх үйлчилгээ мэргэшсэн байх;

Хохирогчид болон эрсдэлд байгаа хүүхэд, эмэгтэйчүүдтэй ажиллах нийгмийн ажилтан, хууль хяналтын болон үйлчилгээний бусад байгууллагын ажилтны мэргэшсэн үйлчилгээ үзүүлэх чадавхийг бэхжүүлнэ.

5.1.5. хөтөлбөрийг Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого, үндэсний бусад хөтөлбөр, төсөлтэй уялдуулах.

Зургаа. Хэрэгжүүлэх арга хэмжээ

6.1. Хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор

ашиглахаас урьдчилан сэргийлэх ажлын талаар дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

6.1.1. хүн худалдах, хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглах, садар самуунд уруу татах, үүнээс гарах сөрөг үр дагавар, хохирлоос урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд сурталчлах, таниулах ажлыг зохион байгуулах;

6.1.2. аялал жуулчлал, тээвэр, үйлчилгээний байгууллагын ажилтнуудыг хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглах, худалдах, хил дамжуулан худалдахаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, хохирогчийг нөхөн сэргээх чиглэлийн чадавхи нэмэгдүүлэх сургалтад хамруулах;

6.1.3. хууль хяналтын байгууллагын ажилтны энэ төрлийн гэмт хэргийн талаархи ойлголт, мэдлэгийг дээшлүүлж, илрүүлэх, тэмцэх арга барил, үр чадварыг нэмэгдүүлж, техникийн дэвшилийг өргөн ашиглах;

6.1.4. хүүхдийг бэлгийн мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх, өөрийгөө хамгаалах чадвартай болгоход чиглэсэн сургалт, сурталчилгааны ажлыг хүртээмжтэй, үр өгөөжтэй зохион байгуулах;

6.1.5. бэлгийн мөлжлөгт өртөж болзошгүй эрсдэлт бүлгийн гэр бүлд чиглэгдсэн сургалт, сурталчилгааны үйл ажиллагаа зохион байгуулахад иргэний нийгмийн оролцоог хангах;

5.1.6. гадаадад зорчигч болон гадаадаас ирж бэлтгэл зорчигчдын бүртгэл, хяналтын системийг боловсронгуй болгож, хүүхэд, эмэгтэйчүүд гадаадад хууль бусаар гарахаас урьдчилан сэргийлэх;

6.1.7. хэвлэл мэдээлэл, үйлчилгээний байгууллагын ажилтнуудад зориулсан хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглагдахаас хамгаалах сургалтыг үе шаттайгаар тогтмол зохион байгуулах, тэдний чадавхийг бэхжүүлэхэд иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх;

6.1.8. хүүхэд хамгаалал, гэр бүлийн асуудлаар мэргэшсэн нийгмийн ажилтныг бэлтгэх, тэднийг чадваржуулах, тэдгээрт зориулж гарын авлага, сурталчилгааны материал боловсруулах арга хэмжээг дэмжих;

6.1.9. хүүхэд, эмэгтэйчүүдийг интернэтийн секс сурталчилгаанд ашиглагдахаас хамгаалах нөхцөлийг бүрдүүлэх.

6.2. Хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах талаар дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

6.2.1. хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглах бүх хэлбэрийг таслан зогсоох асуудлаар садар самуунтай тэмцэх

талаархи болон бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах;

6.2.2. үндэстэн дамнансан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын Конвенц болон түүний "Хүн ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдийг хил дамжуулан худалдаалахын эсрэг" Нэмэлт Протоколд нэгдэн орох асуудлыг судлан зохио бэлтгэл хангах;

6.2.3. хүүхэд хамгааллын чиглэлээр хүчин төгөлдөр мөрдөгдөг байгаа хууль тогтоомжид харьцуулсан судалгаа хийж, олон улсын гэрээ, Конвенцийн шаардлагад нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийж;

6.2.4. хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглах, худалдах гэмт хэрэгтэй тэмцэх хүчний болон хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох;

6.2.5. иргэний бүртгэл мэдээлэл, хилийн шалган нэвтрүүлэх, хууль сахиулах болон холбогдох байгууллагын нэгдсэн мэдээллийн сүлжээг бий болгож ажилтныг нь чадавхижуулах;

6.2.6. энэ төрлийн гэмт хэргийн улмаас хохирсон хүүхэд эмэгтэйчүүдийн нас, бие махбодь, сэтгэл санааны болон бусад хохирлыг тогтоох шинжээчдийн багуудыг байгуулан ажиллуулж, орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангах;

6.2.7. хүлээн авагч улсад нь хохирогчийг аврах, хамгаалах, эрх зүйн туслалцаа болон бусад үйлчилгээ үзүүлэхэд иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлж Монгол Улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газруудын энэ чиглэлээрх үйл ажиллагааг идэвхжүүлэх.

6.3. Хохирогчдыг хэвийн амьдралд нь буцаан нийгэмшүүлэх, нөхөн сэргээх чиглэлээр дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

6.3.1. садар самуун, бэлгийн хүчирхийлэл, арилжаанд өртсөн болон өртеж болзошгүй хүүхэд, эмэгтэйчүүдийн талаархи мэдээллийн сүлжээг бий болгох;

6.3.2. хохирогч хүүхэд, эмэгтэйчүүдийн эрхийг нөхөн сэргээх, тэдний хувийн нууцыг хадгалах, нэр төрийг нь хамгаалах чиглэлээр хууль хяналт, орон нутгийн засаг захиргааны байгууллагын ажилтны мэргэжлийн ур чадвар, эрх зүйн мэдлэгийг системтэй нэмэгдүүлэх;

6.3.3. хохирогч болон эрсдэлд байгаа хүүхдийн боловсролыг нөхөн олгох, нийгэмшүүлэхэд бүх талын дэмжлэгийг үзүүлэх;

6.3.4. бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглагдаж эрсдэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүдэд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, тэднийг нөхөн сэргээх үйлчилгээг бий болгох;

6.3.5. хохирогч болон эрсдэлд байгаа хүүхдийг эрхээ хамгаалах, нийгэмшин төлөвших, нийгмийн амьдралд оролцох чадварт сурах үйл ажиллагааг дэмжих;

6.3.6. хохирогч хүүхэд, эмэгтэйчүүдэд туслалцаа үзүүлэх "итгэлтэй утас", хамгаалах

байрны үйлчилгээг хүүхэд, эмэгтэйчүүдэд ээлтэй, тохиромжтой хэлбэрээр хөгжүүлэх арга хэмжээ авах;

6.3.7. хууль, эрх зүйн болон сэтгэл зүйн зөвлөлгөө өгөх нэгжийг хохирогчдын амьдрах орчны ойролцоо ажиллуулах, сэтгэл зүйн сэргээн засах үйлчилгээг бий болгох чиглэлээр төрийн бус байгууллагын гаргасан санал, санаачилгыг дэмжих;

6.3.8. хүүхэд, эмэгтэйчүүдэд учирсан хохирлыг барагдуулах эрх зүйн орчинг бий болгох асуудлыг судлан шийдвэрлэх;

6.3.9. садар самуун явдал, бэлгийн хүчирхийллийн золиос болсон хүүхэд, эмэгтэйчүүдийг нөхөн сэргээх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, иргэдийн үйл ажиллагааг урамшуулан дэмжих;

6.3.10. хүүхэд, эцэг эх, тэдний гэр бүлийн гишүүд, багш, нийгмийн ажилтнуудад хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын талаархи ойлголт хандлагыг төлөвшүүлэх сурталчилгааг өргөжүүлэх;

6.3.11. энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болсон хүүхэд, эмэгтэйчүүд эх орон, орон нутагтаа эргэн ирэх, нийгэмших эрх зүй, нийгмийн таатай нөхцөлийг бүрдүүлэх.

Долоо. Хөтөлбөрийн үр дүн

7.1. Хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглах, худалдахаас хамгаалах эрх зүйн орчин боловсронгуй болно.

7.2. Хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглах, худалдахаас сэргийлэх асуудлаар нийгмийн бүх давхаргын ойлголт нэмэгдэж, зөв хандлага төлөвшинэ.

7.3. Суурь боловсролоор олгогдож байгаа эрх зүй, эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрт бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах асуудал тусгагдсанаар ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын мэдлэг дээшилнэ.

7.4. Хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн эрх, нийгмийн хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагын чадавхи бэхжин тэдгээрийн үйл ажиллагааны уялдаа холбоо сайжирна.

7.5. Садар самуун явдал, бэлгийн хүчирхийлэл, арилжаанд өртсөн болон өртеж болзошгүй эрсдэлтэй нөхцөлд амьдарч байгаа хүүхэд, эмэгтэйчүүдийн тоог бууруулж, тэдэнд үзүүлэх боловсрол, нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, сэтгэл зүйн нөхөн сэргээх үйлчилгээ бий болно.

7.6. Хил дамжин худалдагдсан хүүхэд, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, нөхөн сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх үйл ажиллагаа сайжирна.

7.7. Хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглах, худалдах боломж нөхцөлийг сааруулж түүнд тавих хяналт сайжирна.

Засгийн газрын 2005 оны 234 дүгээр
тогтоолын 2 дугаар хэсэрлэлт

**ХҮН ХУДАЛДАХ, ХҮҮХЭД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ БЭЛГИЙН
МӨЛЖЛӨГИЙН ЗОРИЛГООР АШИГЛАХААС ХАМГААЛАХ
ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ 2006-2007 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ЧИГЛЭЛ**

№	Үйл ажиллагаа	Хариуцах байгууллага	Хэрэгжих хугацаа
Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар			
1	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хяналт тавих зөвлөлийг хуралдуулж, ажлын хэсгүүдийг байгуулан ажил, үүргийн хуваарийг батлах.	НХХЯ, Зөвлөл	2005 оноос жилийн турш
2	Хөтөлбөрийн Зөвлөлийн ажиллах журмыг баталж, мөрдүүлэх	НХХЯ	2005 онд
3	Зөвлөлийн ажилд шаардагдах хөрөнгийн тооцоог боловсруулж шийдвэрлүүлэх	Зөвлөл	Жил бүр
4	Зөвлөлийн ажлын тайланг боловсруулах, мэдээлэл, зөвлөмж боловсруулах	НХХЯ, Зөвлөл	Жилийн турш
Хоёр. Хууль зүйн орчинг боловсронгуй болгох талаар			
5	Хүчин төгөлдөр мөрдөж байгаа үндэсний хууль тогтоомжид судалгаа хийж, олон улсын гэрээ конвенцийн шаардлагад нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх.	ХЗДХЯ, ГХЯ	2006 онд
6	Хүн худалдах, хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглах бүх хэлбэрийг таслан зогсоох асуудлаар садар самуунтай тэмцэх талаархи болон бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулах, хэлэлцүүлэх, хамтарч ажиллах	НХХЯ, ХЗДХЯ	2006-2007 онд
7	Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг Конвенци болон түүний Эмэгтэйчүүд, хүүхдийг хил дамжуулан худалдахын эсрэг Нэмэлт Протоколд нэгдэн ороход дэмжлэг үзүүлэх	ХЗДХЯ, ГХЯ	2005 онд
8	Хууль хяналтын байгууллагын ажилтны чадавхийг бэхжүүлж, хохирогчтой ажиллах ур чадвар эзэмшүүлэх	НХХЯ, ХЗДХЯ	2006-2007 онд
9	Энэ чиглэлээр гарсан хууль тогтоомжийг хүүхдэд ээлтэй хэлбэрээр хэрэгжүүлэх талаар холбогдох байгууллагын чадавхийг бэхжүүлэх	НХХЯ, ХЗДХЯ	2005-2007 онд
10	Хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглах, худалдахтай тэмцэх чиглэлээр эрх зүйн тусалцаа үзүүлэх гэрээ, хэлэлцээрийг холбогдох улстай байгуулах арга хэмжээ авах	ХЗДХЯ, ГХЯ	2006-2007 онд
11	Иргэний бүртгэл, Монгол Улсын иргэн гадаадад зорчих тухай хууль тогтоомжийн насанд хүрээгүй хүмүүсийн бүртгэл, хяналттай холбогдох заалтыг судлан дүгнэлт гаргах	НХХЯ, ИБМУТ, ХХЕГ	2005 онд
12	Хүүхдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглах бүх хэлбэрийг таслан зогсоох талаар хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар холбогдох байгууллага, иргэний нийгмийн байгууллагатай хамтарсан хэлэлцүүлэг хийх	НХХЯ, ХЗДХЯ	2006 онд
Гурав. Урьдчилан сэргийлэх ажлын талаар			
13	Хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглах, худалдахын эсрэг үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллагууд мэдээлэл солилцох, хамтарч ажиллах тохиромжтой хэлбэрийг бий болгож мэдээллийн сүлжээтэй болох	НХХЯ, ХЗДХЯ	2005-2007 онд

14	Хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглах, худалдахаас хамгаалах компаниг ажил зохион байгуулах	НХХЯ, ОУБ, ТББ	Жил бүр
15	Хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглах, садар самуунд уруу татах гэмт хэргийн сөрөг үр дагавар, хор уршгийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан олон нийтийн сурталчилгааг өргөжүүлэх	НХХЯ, ОУБ, ТББ	2005-2007 онд
16	Энэ чиглэлээр хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжийг сурталчлах, таниулах ажлыг зохиох	НХХЯ, ХЗДХЯ, ТББ	2005-2007 онд
17	Зочид буудал, саун, массаж, кароже, аялал жуулчлал, тээвэр болон бусад үйлчилгээний байгууллагын ажилтнуудад зориулсан сургалт, уулзалтыг үе шаттай зохион явуулах	НХХЯ, ЗТАЖЯ, ҮХЯ	2005-2007 онд
18	Хүүхдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах өс зүйн хэм хэмжээнд аялал, жуулчлал, тээвэр үйлчилгээний байгууллага нэгдэх ажлыг эрчимжүүлэх	НХХЯ, ЗТАЖЯ, УМХГ	2006 онд
19	Бэлгийн мөлжлөгт өртөх эрсдэлтэй хүүхдийн эцэг эх, гэр бүлд чиглэгдсэн сурталчилгаа, нийгмийн ажлын арга барилыг төлөвшүүлж зохион байгуулах	НХХЯ	2005 онд
20	Хорооны болон сургуулийн нийгмийн ажилтнуудыг хүүхэд хамгааллын асуудлаархи гарын авлага бусад сурталчилгааны материалаар хангах	НХХЯ	2006 онд
21	Хилийн боомтод ажиллагсад, зорчигчдод зориулсан хүүхэд хамгааллын талаархи ойлголтыг нэмэгдүүлэх өвлөмж, гарын авлага, сурталчилгааны материал боловсруулах, тараах	НХХЯ, ХЗДХЯ	2006 оноос
22	Бэлгийн хүчирхийлэлээс сэргийлэх, хамгаалах мэдлэг, мэдээллийг эрүүл мэнд, эрх зүйн хичээлийн агуулгад багтаан оруулах арга хэмжээг авах	НХХЯ, БСШУЯ, ТББ	2005-2007 он
23	Хүн худалдах гэмт хэргийг зохион байгуулсан, үйлдсэн, оролцсон, нуун дарагдуулсан этгээдэд ногдуулах хариуцлагыг чангатгах чиглэлээр санал боловсруулах	ХЗДХЯ, НХХЯ, ЦЕГ	2005-2007 он
24	Хүүхдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглах, худалдах, садар самуунд уруу татах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр амжилт олсон улс орны туршлагыг судлах	НХХЯ, ОУБ-ууд	2005-2012 он
25	Хүүхдийг садар самуунд уруу татах зорилгоор порнографыг сурталчилж байгаа интернэт сайтыг хаах, сүлжээнд хяналт тавих, хязгаарлах тогтолцоог судалж хэрэгжүүлэх	ХЗДХЯ, МХХТГ, БСШУЯ	2005 оноос
26	Хүүхдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглах, худалдахаас урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор үйлчилгээний байгууллагад тогтмол үзлэг, шалгалт явуулж хэвших	УМХГ, ЦЕГ	2005 оноос жил бүр

Дөрөв. Нөхөн сэргээх, нийгэмшүүлэх талаар

27	Хүн худалдах гэмт хэргийн хохирогчдын нууцыг хамгаалах талаархи хэвлэл мэдээлэл, хууль хяналтын байгууллагын ажилтны чадавхийг бий болгох	ХЗДХЯ, Засаг дарга нар	2006 оноос
28	Хохирогчдод сэтгэл зүйн болон бусад зөвлөлгөө өгөх нэгжийг байгуулан ажиллуулах	НХХЯ, Засаг дарга нар, ТББ	2006 оноос
29	Хүний эрх, хүүхдийн эрх, жэндэрийн асуудлаар багш, нийгмийн ажилтнуудын ойлголт, хандлагыг сайжруулах үйл ажиллагааг өргөжүүлэх	ХТҮГ, Нийгмийн ажилтны холбоо, ТББ	2005 оноос
30	Хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагыг дэмжих, хамтарч ажиллах	НХХЯ, ХЭТ	2005-2007 онд

31	Хохирогчдыг нөхөн сэргээх, нийгэмшүүлэх чиглэлээр олон улсын байгууллагатай хамтран ажиллах боломжийг судалж шийдвэрлэх	НХХЯ, ОУБ-ууд	2005-2007 он
32	Хохирсон хүүхдийн эцэг эх, гэр бүлд зөвлөлгөө өгөх, хууль зүйн туслалцаа үзүүлэх дэмжлэгийн орчныг бий болгох	НХХЯ, ХЗДХЯ, ХЭТ	2005-2007 он
33	Хил дамжин худалдагдсан хүүхэд, эмэгтэйчүүдийг эх орондоо эргэж ирэхэд нь гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газар дэмжлэг үзүүлэх эрх зүй, эдийн засгийн орчныг оновчтой болгох	ГХЯ, НХХЯ	2005-2007 он
34	Хохирогчдыг амьдрах ухаан, орлогын байнгын эх үүсвэртэй болгох мэргэжлийн сургалтад хамруулах, ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөрт бэлгийн мөлжлөгөөс сэргийлэх асуудлыг тусгах	НХХЯ, БСШУЯ	2005 оноос
35	Хохирогчдоод учирсан сэтгэл санаа, эд материалын хохирлыг нөхөх тогтолцоог бий болгох асуудлыг судлан шийдвэрлэх	ХЗДХЯ, НХХЯ, ТББ	2005 оноос

Тав. Бусад ажлын талаар

36	Садар самуунд уруу татагдсан, бэлгийн хүчирхийлэлд өртсөн болон өрөж болзошгүй хүүхэд, эмэгтэйчүүдийн талаар мэдээлэл цуглуулах, судалгаа хийхдээ тэднийг өөрсдийг нь оролцуулах, санал бодлыг нь сонсох бололцоог бүрдүүлэх	НХХЯ, ЦЕГ	Жилийн турш
37	Гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх үйл ажиллагаанд иргэний нийгэм, ялангуяа хүүхэд, залуучуудын үүсгэл санаачилгын үйл ажиллагааг дэмжих	ХТҮГ, ТББ	Жил бүр
38	Орон нутгийн үйл ажиллагааг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	ХТҮГ, ТББ	2005 оноос
39	Иргэний нийгэм, оролцооны байгууллагын боловсон хүчний чадавхийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	ХТҮГ, ТББ	2005-2007 он
40	Хүүхэд, залуучуудын оролцооны бүлгээс санаачилсан үйл ажиллагааг дэмжих	ХТҮГ, ТББ	2006 оноос
41	Бэлгийн мөлжлөгөөс сэргийлэх, хамгаалах, сээрэмжлүүлэг, мэдээлэл гаргах, хэлэлцүүлэг өрнүүлэх, хохирогчдоос мэдээллийг шуурхай авах боломжийг хангасан интернэт сайтыг бий болгож байнга шинэчлэх	ГХЯ, НХХЯ, ХЗДХЯ	2005 оноос

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр

Дугаар 235

Улаанбаатар хот

Үндэсний спортын III наадам зохион байгуулах тухай

Биеийн тамир, спортын тухай хуулийн 7.1.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас Т.Ганди, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасуяай.

Тулгар төр байгуулагдсаны 800 жил. Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 85 жилийн ойн хүрээнд Үндэсний спортын Ш наадмыг орон даяар зохион байгуулахыг Эрүүл мэндийн сайд

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Ц.ЭЛБЭГДОРЖ

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД Т.ГАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр

Дугаар 237

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогтод үүрэг болгосуйай.

нь:

1. Засгийн газрын гишүүний ажил хүлээлцэх журмыг хавсралт ёсор баталсуйай.
2. Энэ журмын биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН
ШАДАР САЙД Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА С.БАЯРЦОГТ

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮНИЙ АЖИЛ ХҮЛЭЭЛЦЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Засгийн газрын гишүүн ажил хүлээлцэхэд тавих нөхцөл, шаардлага, эрх, үүргийг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Улсын Их Хурлаас дараахь асуудлаар шийдвэр гаргасан нөхцөлд Засгийн газрын гишүүн энэ журмын дагуу ажил хүлээлцэнэ:

1.2.1. Улсын Их хурлаас Засгийн газрыг эмхлэн байгуулсан;

1.2.2. Үндсэн хуулийн Дөчин гурав, Дөчин дөрөвдүгээр зүйлд зааснаар Засгийн газрыг огцруулж, шинээр байгуулсан;

1.2.3. огцорсон, чөлөөлөгдсөн, эсхүл нас нөхцсөн Засгийн газрын гишүүнийг нөхөн томилсон.

1.3. Засгийн газрын гишүүний ажил хүлээлцэх ажлыг зохион байгуулах комисс (цаашид "Комисс" гэх)-ыг Ерөнхий сайд томилно.

1.4. Засгийн газрын гишүүний ажлыг Улсын Их Хурлаас зохих шийдвэр гарсан даруй хүлээлцэнэ. Ажил хүлээн авч байгаа болон хүлээлгэн өгч байгаа сайд биеийн эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаас хүрэлцэн ирэх боломжгүй тохиолдолд Ерөнхий сайдын шийдвэрээр ажил хүлээлцэхийг тухайн шалтгааныг арилтал түр хугацаагаар хойшлуулж болно.

Хоёр. Засгийн газрыг эмхлэн байгуулсан үед ажил хүлээлцэх

2.1. Энэ журмын 1.2.1-д заасны дагуу Засгийн газрыг шинээр эмхлэн байгуулсан үед бүрэн эрхийн нь хугацаа дугаарваг болсон сайд шинээр томилогдсон сайдад ажлаа биечлэн хүлээлгэж өгнө.

2.2. Засгийн газрыг огцруулж, шинээр байгуулсан үед энэ журмын 2.1, 2.2-т заасантай нэгэн адил ажил хүлээлцэнэ.

Гурав. Огцорсон, чөлөөлөгдсөн, нас нөхцсөн сайдыг нөхөн томилоход ажил хүлээлцэх

3.1. Сайд огцорсон, чөлөөлөгдсөн, нас нөхцсөн тохиолдолд түүний үүргийг хариуцан гүйцэтгэж байгаа Монгол Улсын сайд нөхөн томилогдсон сайдад ажлыг нь хүлээлгэж өгнө.

3.2. Ажил хүлээлцэх үед огцорсон, чөлөөлөгдсөн сайдыг байлцуулж болно.

Дөрөв. Ажил хүлээлцэх журам

4.1. Ажлаа хүлээлгэн өгч байгаа сайд өөрийн тэргүүдсэн яам болон эрхлэх асуудлын хүрээний үйл ажиллагаа явуулж байгаа агентлаг, бусад байгууллагын удирдлагын хамт шинээр буюу нөхөн томилогдсон сайдыг хүлээн авч, яамны тамгыг түүнд хүлээлгэж өгнө.

4.2. Яамны тамгыг хүлээлгэж өгсний дараа шинээр буюу нөхөн томилогдсон сайдад түүний эрхлэх асуудлын хүрээ, холбогдох байгууллагын

зохион байгуулалт, үйл ажиллагааг танилцуулах бөгөөд дараахь асуудлыг заавал танилцуулна:

4.2.1. яамны бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг;

4.2.2. "Яамны зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны стратегийн хөтөлбөр" болон "Үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө"-нд туссан эрхэм зорилго, хэтийн зорилт, тэдгээрийн биелэлт, цаашид хэрэгжүүлэх бодлого, зорилт;

4.2.3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд Ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээ, түүний биелэлт;

4.2.4. эрхлэх асуудлын хүрээний төсөв, санхүүжилт болон гадаадын эзэл, тусламж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээ, тэдгээрийн хэрэгжилтийн явц;

4.2.5. яамны сүүлийн хоёр жилийн санхүүгийн тайлан тэнцэл, яамны мэдэлд байгаа эд хөрөнгийн жагсаалт, үнэлгээ;

4.2.6. тухайн сайд албан тушаалынхаа дагуу Улсын Их Хурал, Засгийн газар, Ерөнхий сайдын шийдвэрээр байгуулсан хороо, комисс, зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдүүхэнд орж ажилладаг бол тэдгээрийн тухай танилцуулна;

4.2.7. шинээр буюу нөхөн томилогдсон сайдын үзэж, танилцахыг хүссэн бусад асуудал.

4.3. Энэ журмын 4.2.3-4.2.7-д заасан асуудал бүрийг танилцуулахдаа холбогдох баримт бичиг, тайлан тэнцэл, материалыг шинээр буюу нөхөн томилогдсон сайдад хүлээлгэж өгсөн байвал зохино.

4.4. Ерөнхий сайдын томилсон комисс ажил хүлээлцсэн явцын тухай тэмдэглэл хөтлөх, ажил хүлээлцсэн акт үйлдэх ажлыг хариуцан зохион байгуулна.

4.5. Ажил хүлээлцсэн актад дараахь зүйлийг тусгана:

4.5.1. ажил хүлээлцсэн газар, хугацаа, он, сар, өдөр, ажил хүлээлцэхэд оролцсон албан тушаалтан;

4.5.2. энэ журмын 4.2-т заасан асуудал бүрийг танилцуулсан байдал, ажил хүлээлцэх хүрээнд явагдсан бусад ажиллагаа, арга хэмжээ;

4.5.3. хүлээлгэж өгсөн материал, баримт бичгийн жагсаалт, тоо хэмжээ;

4.5.4. сайд нарын актад тусгуулахыг хүссэн бусад асуудал.

4.6. Ажил хүлээлцсэн тухай актыг гурван хувь үйлдэх бөгөөд ажил хүлээлгэн өгсөн сайд болон хүлээн авсан сайд танилцаж гарын үсэг зурсан байна.

4.7. Ажил хүлээлцсэн тухай тэмдэглэлийг тухайн яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын

дарга хөтөлнө. Ажил хүлээлцсэн тухай тэмдэглэлд тэмдэглэл хөтөлсөн албан тушаалтан болон комиссын гишүүд гарын үсэг зурна.

4.8. Яамыг өөрчлөн зохион байгуулсантай холбогдуулан нэг сайд хэд хэдэн шинэ сайдад, эсхүл хэд хэдэн сайд нэг сайдад ажлаа хүлээлгэж өгөх тохиолдолд сайд тус бүртэй ажил хүлээлцсэн акт үйлдэнэ.

Тав. Ажил хүлээлцэх сайд нарын эрх, үүрэг

5.1. Ажил хүлээлгэн өгч байгаа сайд дараахь үүрэг хүлээнэ:

5.1.1. шинээр буюу нөхөн томилогдсон сайдад түүний эрхлэх асуудлын хүрээ, чиг үүрэг бүрийн талаар мэдээлэл өгөх;

5.1.2. яам, агентлаг, бусад байгууллагуудын зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэл, удирдлага, төсөв, санхүүгийн талаар тодорхой танилцуулах;

5.1.3. ажил хүлээлцэхэд ач холбогдол бүхий баримт бичиг, материалыг бүрэн хэмжээгээр хүлээлгэн өгөх;

5.1.4. албан ажлын хэрэгцээнд хэрэглэж байсан эд хөрөнгө, техник хэрэгслийг хүлээлгэн өгч цалин хөлс, бусад тооцоог хийж дуусгах;

5.1.5. ажил хүлээлцсэн актыг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг хүлээн зөвшөөрөх

боломжгүй гэж үзвэл бичгээр тайлбар гарган актад хавсаргах.

5.2. Шинээр буюу нөхөн томилогдсон сайд дараахь эрхтэй:

5.2.1. ач холбогдолтой гэж үзсэн тодорхой асуудлыг тусгайлан хүлээлгэн өгөхийг шаардах;

5.2.2. шаардлагатай гэж үзвэл яам, агентлагийн удирдлагыг нэг бүрчлэн хүлээн авч уулзах, нэмэлт материал, баримт бичиг гаргуулах;

5.2.3. ажил хүлээлцсэн актыг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзвэл бичгээр тайлбар гарган актад хавсаргах.

Зургаа. Ажил хүлээлцэх үед яам, агентлаг, бусад байгууллагуудын хүлээх үүрэг

6.1. Ажил хүлээлцэх үед холбогдох яам, агентлаг, бусад байгууллагын удирдлага дараахь үүрэг хүлээнэ:

6.1.1. холбогдох материал, баримт бичиг, тайлан тэнцлийг шинээр буюу нөхөн томилогдсон сайдад танилцуулахад бэлэн болгох, түүний шаардсан нэмэлт материал, баримт бичгийг гаргаж өгөх;

6.1.2. Ажил хүлээлцэх үед яам, агентлаг, бусад байгууллагын холбогдох ажилтнуудыг бэлэн байлгах.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 11 дүгээр сарын 30—ны өдөр

Дугаар 238

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 13¹ 2-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Согтууруулах ундааг хураах, шинжилгээ хийх, улсын орлого болгож борлуулах журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Монгол

Улсын сайд Д.Дорлигжав, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН
ШАДАР САЙД

Ч.УЛААН

Засгийн газрын 2005 оны 238 дугаар тогтоолын хавсралт

СОГТУУРУУЛАХ УНДААГ ХУРААН АВАХ, ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, УЛСЫН ОРЛОГО БОЛГОЖ БОРЛУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журам нь Эрүүгийн хуулийн 161, 175 дугаар зүйл, Захиргааны хариуцлагын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан гэмт хэрэг, захиргааны зөрчил, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль болон бусад хууль тогтоомжийг зөрчсөнтэй холбогдуулан согтууруулах ундааг хураах, шинжилгээ хийх, улсын орлого болгож борлуулахтай холбогдсон харилцааг зохицуулна.

Хоёр. Согтууруулах ундааг хураах

2.1. Согтууруулах ундааг өмчлөгчөөс нь дор дурдсан хуульд заасан журмыг үндэслэж эрх бүхий

албан тушаалтнууд дараахь харьяаллын дагуу хураана:

2.1.1. хилийн шалган нэвтрүүлэх болон гаалийн хяналт шалгалт, бүрдүүлэлтийн явцад бүх төрлийн согтууруулах ундааг хууль тогтоомж зөрчиж буюу хууль бусаар улсын хилээр нэвтрүүлэхийг завдсан, түүнчлэн нэвтрүүлсэн бол хил хамгаалах байгууллагын эрх бүхий ажилтан болон гаалийн улсын байцаагч, Хилийн тухай хуулийн 33 дугаар зүйл, Гаалийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу;

2.1.2. Захиргааны хариуцлагын тухай хуулийн 42 дугаар зүйл болон Архидан

согтуурахтай тэмцэх тухай хуулиар тогтоосон журмыг зөрчсөн бол Захиргааны хариуцлагын тухай хуулийн 10 дугаар зүйл, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан эрх бүхий албан тушаалтан;

2.1.3. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан журмын дагуу шүүгч, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч;

2.1.4. Татварын ерөнхий хуулийн 24.2.3-т заасны дагуу татварын улсын байцаагч;

2.1.5. Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 16.3.4, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9.6-д заасны дагуу мэргэжлийн хяналтын улсын байцаагч;

2.1.6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 10.1.4, 34.1.1-д заасны дагуу шийдвэр гүйцэтгэгч.

2.2. Энэ журмын 2.1-д заасан хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч болон бусад эрх бүхий албан тушаалтан согтууруулах ундааг хураан авахдаа тэмдэглэл үйлдэнэ.

2.3. Согтууруулах ундааг хураахдаа түүний өмчлөгч болон хоёроос доошгүй хөндлөнгийн гэрчийг заавал байлцуулж шаардлагатай гэж үзвэл хэвлэл мэдээлэл, төрийн бус байгууллагын төлөөлөл, иргэдийг оролцуулж болно.

2.4. Согтууруулах ундааны өмчлөгч нь тогтоогдоогүй буюу оргон зайлсан тохиолдолд тухайн нутаг дэвсгэрийн прокурорын хяналтын дор хураана.

2.5. Хураан авах тухай тэмдэглэлд согтууруулах ундааг хураасан он, сар, өдөр, уг ажиллагаанд оролцсон, байлцсан хүмүүсийн овог нэр, албан тушаал, хаяг, хураагдсан согтууруулах ундааны хэмжээ, зориулалт, өнгө, үнэ, хураалгасан хүний овог нэр, хаяг, хураасан газар, орны байршил, баримт бичгийн дугаар, уг зүйлийг автумажилсэн лац, ломбоны дугаар, тээвэрлэсэн автомашины марк, дугаар, жолоочийн овог нэр, хураан авах ажиллагааны явц байдал, байлцсан хүмүүсийн гаргасан санал болон түүнийг хэрхэн шийдвэрлэсэн талаар дэлгэрэнгүй тусгаж, хураан авах ажиллагаанд оролцсон болон байлцсан хүн бүрийн гарын үсгийг зуруулна.

2.6. Хураан авах тухай тэмдэглэлийн нэг хувийг гэмт хэрэг үйлдсэн буюу зөрчил гаргасан этгээдэд өгнө. Хэрэв согтууруулах ундааны өмчлөгч нь тогтоогдоогүй буюу оргон зайлсан тохиолдолд хураан авах тухай тэмдэглэлд энэ тухай тэмдэглэж эрүүгийн хэрэг болон захиргааны зөрчлийн материалд хавсаргана.

2.7. Согтууруулах ундааг хураан авахдаа түүний өмчлөгч нь байвал Засгийн газрын 1995 оны 131 дүгээр тогтоолоор баталсан "Захиргааны журмаар эд зүйл хураах, улсын орлого болгох, устгах нийтлэг журам"-ын 2.2-т заасан тооцооны хуудас олгоно.

2.8. Шаардлагатай гэж үзвэл согтууруулах ундааны биет байдал, хураан авах ажиллагааны явцын тухай гэрэл зург авч, дүрс, дууны бичлэг

хийж тэдгээрийг эрүүгийн хэрэг болон захиргааны зөрчлийн материалд хавсаргана.

2.9. Хураагдсан согтууруулах ундааны бүрэн бүтэн байдлыг хураан авах, хадгалах, борлуулах үүрэг хүлээсэн тухайн байгууллагын дарга болон хураан авсан албан тушаалтан биечлэн хариуцна.

2.10. Эрх бүхий байгууллага, албан тушаалтан хураагдсан согтууруулах ундаатай холбоотой асуудлаар эрүүгийн хэрэг үүсгэж шалцаж байгаа тохиолдолд уг хэргийг шүүхээс эцэслэн шийдвэрлэсний дараа хураагдсан согтууруулах ундааны асуудлыг шийдвэрлэнэ.

Гурав. Хураагдсан согтууруулах ундаанд шинжилгээ хийх

3.1. Согтууруулах ундааг хураан авсан буюу эрүүгийн хэрэг, захиргааны зөрчлийг шалгаж байгаа хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, эрх бүхий албан тушаалтан нь улсын итгэмжлэгдсэн лабораториор согтууруулах ундаанд шинжилгээ хийлгэх тухай тогтоол үйлдэж 48 цагийн дотор хүргүүлнэ.

3.2. Хот, суурин газраас алслагдсан улирлын ажиллагаатай хилийн боомтод ажиллаж байгаа хил, гаалийн ажилтан, сумын цагдаагийн алба хаагч согтууруулах ундаа хураагдсан тухайд удирдлагадаа нэн даруй илтгэж зохих журмын дагуу шийдвэрлэнэ.

3.3. Улсын итгэмжлэгдсэн лабораторийн шинжээч, мэргэжилтэн нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, эрх бүхий албан тушаалтны үйлдсэн тогтоолын дагуу хураагдсан согтууруулах ундааны сав тус бүрээс дээж авч, шинжилгээг тэргүүн ээлжинд хийж өгнө.

3.4. Лабораторийн шинжээч, мэргэжилтэн нь 7 хоногийн дотор дараахь дүгнэлтийн аль нэгийг гаргана:

3.4.1. эрүүл ахуйн болон стандартын шаардлага хангасан тул хүнсэнд хэрэглэж болох;

3.4.2. техникийн болон хүнсний бус бусад зориулалтаар ашиглаж болох;

3.4.3. энэ журмын 3.4.1, 3.4.2-т заасан зориулалтаар ашиглах боломжгүй тул холбогдох журмын дагуу устгах.

3.5. Хураагдсан согтууруулах ундааг устгах дүгнэлт гарсан бол устгах ажлыг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч болон Улсын ерөнхий прокурорын хамтарсан тушаалаар баталсан журмын дагуу гүйцэтгэнэ.

Дөрөв. Согтууруулах ундааг улсын орлого болгож борлуулах

4.1. Эрүүгийн хэрэг, захиргааны зөрчлийн улмаас хураагдсан согтууруулах ундааг улсын орлого болгож борлуулах ажлыг Засгийн газрын 1995 оны 131 дүгээр тогтоолоор баталсан "Захиргааны журмаар эд зүйл хураах, улсын орлого болгох, устгах нийтлэг журам"-ын 2.4-т заасан сум,

дүүргийн Засаг даргын дэргэдэх захиргааны зөвлөл (цаашид Зөвлөл гэх) зохион байгуулна.

4.2. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, эрх бүхий албан тушаалтан нь энэ журмын 3.4.1, 3.4.2-т заасан шинжилгээний дүгнэлтийг үндэслэн хураагдсан согтууруулах ундааг улсын орлого болгох тухай саналыг зөвлөлийн даргад бичгээр уламжилна.

4.3. Зөвлөл нь саналыг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор согтууруулах ундааг улсын орлого болгож борлуулах тухай сум, дүүргийн Засаг даргын захирамж гаргуулан, үнэлгээ хийнэ.

4.4. Согтууруулах ундааны үнийг тогтоохдоо тухайн үеийн зах зээлийн үнэ ханшийн жишгийг харгалзана.

4.5. Хураагдсан согтууруулах ундааг түүнийг үйлдвэрлэх, худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжид дуудлага худалдаагаар борлуулна.

4.6. Хураагдсан спиртийг согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжид Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 51.1-д заасан журмыг харгалзан дуудлага худалдаагаар борлуулна.

4.7. Хураагдсан согтууруулах ундааг худалдаж борлуулснаас олсон орлогыг улсын төсөвт оруулна.

4.8. Согтууруулах ундааг хурааж улсын орлого болгож борлуулсан мэдээг энэхүү журмын хавсралтад заасан хүснэгтийн дагуу гарган Зөвлөл нь улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь уг мэдээг улирал бүрийн эхний сарын 10-ны дотор хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус хүргүүлнэ.

Тав. Хяналт тавих

5.1. Энэхүү журмын биелэлтэд Засаг дарга, шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, хил хамгаалах, гааль, татвар, мэргэжлийн хяналтын байгууллагын дарга болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах бүх шатны зөвлөл тус тусын эрх хэмжээний хүрээнд хяналт тавьж ажиллана.

5.2. Согтууруулах ундааг хураан авах, улсын орлого болгож борлуулах явцад холбогдох хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад зохиц шатны прокурор хяналт тавина.

Соётууруулах ундааг хураах, шинжилгээ хийх, улсын орлого боловч борлуулах журмын хавсралт

СОГТУУРУУЛАХ УНДААГ ХУРААЖ, УЛСЫН ОРЛОГО БОЛГОСОН, БОРЛУУЛСАН МЭДЭЭ

Огноо	Хураагдсан согтууруулах ундааны төрөл		Хураагдсан согтууруулах ундааны төрөл		Хураагдсан согтууруулах ундааны төрөл		Тамгбар																		
	Хүншин	Техникийн	Гяво	Архи	Дарс	Шийдвэрлэсэн нь																			
8	Хураасан спиртын тоо хэмжээ (n)	Хураасан согтууруулах ундааны тоо хэмжээ (n)				Угтасан орлого болгосон	Үнээс зарж борлуулсан	Хувь																	
								Хувь																	
								Хувь																	

Гарын үсэг

Албан тушаал

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ		
2005 оны 12 дугаар сарын 7-ны өдөр	Дугаар 240	Улаанбаатар хот
<i>Ажлаас чөлөөлөх тухай</i>		
Засгийн газрын тухай хуулийн 18 ^д дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:	телевизийн хэрэг эрхлэх газрын даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
Радио, телевизийн хэрэг эрхлэх газар татан буугдсантай холбогдуулан Баасанжавын Ганболдыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Радио,	МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	Ц.ЭЛБЭГДОРЖ Ч.УЛААН
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ		
2005 оны 12 дугаар сарын 7-ны өдөр	Дугаар 241	Улаанбаатар хот
<i>Засгийн газрын агентлагийг татан буулгах тухай</i>		
Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6.3-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:	в/татан буулгах үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой асуудал гарвал Засгийн газарт оруулж шийдвэрлүүлэх.	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
1. Олон нийтийн радио, телевизийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Радио, телевизийн хэрэг эрхлэх газрыг татан буулгасугай.	3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Радио, телевизийн хэрэг эрхлэх газрын тухай" удирдлагын орон тоог шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 1995 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 206 дугаар тогтоол, Засгийн газрын 2002 оны 162 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагийн жагсаалт"-ын Ерөнхий сайдын эрхлэх хүрээний "Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг" гэсэн хэсгийн 1 дэх заалтыг хүчингүй болсонд тооцугай.	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
2. Дор дурдсан арга хэмжээ авахыг Төрийн өмчийн хороонд даалгасугай:		МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД
а/Радио, телевизийн хэрэг эрхлэх газрыг татан буулгах ажлыг зохион байгуулах комиссыг холбогдох хууль тогтоомжийн дагуу томилон ажиллуулах;		МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА
б/Радио, телевизийн хэрэг эрхлэх газрын ашиглаж байсан төрийн өмчийн хадгалалт хамгаалалтыг хариуцан, Монгол Улсын Их Хурлаас 2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр баталсан Төрийн өмчөөс олон нийтийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай хуульд заасны дагуу Олон нийтийн радио, телевизийн удирдах дээд байгууллагад шилжүүлэх;		Ц.ЭЛБЭГДОРЖ С.БАЯРЦОГТ
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ		
2005 оны 12 дугаар сарын 7-ны өдөр	Дугаар 242	Улаанбаатар хот
<i>Ажлаас чөлөөлөх тухай</i>		
Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 24.1.3-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:	худалдааны яамны Төрийн нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
Өөрийнх нь гаргасан хүсэлтийн дагуу Дамдинсүрэнгийн Сүрэнхорыг Үйлдвэр,	МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	Ц.ЭЛБЭГДОРЖ Ч.УЛААН
	ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД	С.БАТБОЛД
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ		
2005 оны 12 дугаар сарын 14-ний өдөр	Дугаар 247	Улаанбаатар хот
<i>Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай</i>		
Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:	тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 27000 төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоож 2006 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.	
1. Нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн доод хэмжээг 40000 төгрөгөөр, хувь		

2. Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа 34400 төгрөг хүртэлх бүрэн тэтгэврийг 8000 төгрөгөөр, 34400 төгрөгийн бүрэн тэтгэврийг 7000 төгрөгөөр, 34401-60000 төгрөгийн бүрэн тэтгэврийг 6500 төгрөгөөр, 60001-80000 төгрөгийн бүрэн тэтгэврийг 5000 төгрөгөөр, 80001 төгрөгөөс дээшхи бүрэн тэтгэврийг 3000 төгрөгөөр; 21500 хүртэлх төгрөгийн хувь тэнцүүлсэн тэтгэврийг 5750 төгрөгөөр, 21500 төгрөгийн хувь тэнцүүлсэн тэтгэврийг 5600 төгрөгөөр, 21501 төгрөгөөс дээшхи хувь тэнцүүлсэн тэтгэврийг 5500 төгрөгөөр тус тус нэмэгдүүлж 2006 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн тооцон олгох арга хэмжээ авахыг Нийгмийн

хамгаалал, хөдөлмөрийн сайд Ц.Баярсайхан, Сангийн сайд Н.Алтанхуяг нарт даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай" Засгийн газрын 2004 оны 1 дүгээр сарын 7-ны өдрийн 3 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД** Ц.ЭЛБЭГДОРЖ
САНГИЙН САЙД Н.АЛТАНХУЯГ
**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН САЙД** Ц.БАЯРСАЙХАН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 12 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар 250

Улаанбаатар хот

Нэрэмжит болгох тухай

Түүхэн үйл явдал тэмдэглэх, төр, нийгмийн зүтгэлтэн, гавъяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь хүндэтгэх ажлыг зохион байгуулах журам, холбогдох байгууллагын саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

засгийн сургуулийг төр, нийгмийн зүтгэлтэн Жамбын Батмөнхийн нэрэмжит болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД** Ц.ЭЛБЭГДОРЖ
**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД** П.ЦАГААН

Монгол Улсын Их сургуулийн Эдийн

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 12 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар 251

Улаанбаатар хот

Хэлэлцээр батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Засгийн газар хоорондын Хэлэлцээр"-ийг баталсугай.

2005 оны 5 дугаар сарын 25-ны өдөр Парис хотноо байгуулсан "Соёл, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД** Ц.ЭЛБЭГДОРЖ
**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД** П.ЦАГААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 12 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар 255

Улаанбаатар хот

Олон улсын нисэх буудлын нэрийг өөрчлөх тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:
1. Улаанбаатар хотын Буянт-Ухаа дахь олон улсын нисэх буудлын нэрийг 2006 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн "Чингис хаан" хэмээн нэрлэсүгэй.

асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлүүлэхийг Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд Г.Батхүү, Гадаад хэргийн сайд Ц.Мөнх-Оргил нарт даалгасугай.

2. Улаанбаатар хотын олон улсын нисэх буудлын нэрийг Буянт-Ухаа дахь "Чингис хаан" олон улсын буудал болгон өөрчилсөнтэй холбогдуулан гадаад, дотоодын холбогдох байгууллагуудад мэдэгдэх, баримт бичигт өөрчлөлт оруулах

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД** Ц.ЭЛБЭГДОРЖ
**ЗАМ, ТЭЭВЭР, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД** Г.БАТХҮҮ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 265958
Индекс 14003

☎ 329487

Хөвөлгөийн хуудас 2.5